



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

Номт 1 дүгээр баг, Зуунмод сум, Төв аймаг, 41111
Утас: 70273025, И-мэйл: tuv_zdtg@tov.gov.mn

2025. 12. 24 №

01/2148

танай _____-ны № _____-т

Г

Г

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ ТАНАА

Төв аймгийн Алтанбулаг сумын 1 дүгээр багийн иргэн Лувсангийн Цэрэндэжидийг Соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан тул "Соёлын биет бус өвийн шилдэг өвлөн уламжлагч"-д тодорхойлж холбогдох баримт бичгийг хүргүүлж байна.

Хавсралт 19 хуудастай.

ЗАСАГ ДАРГА

Л.ТӨМӨРЧӨДӨР



4125010824



ТӨВ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗАР

Зуунмод сум, Номт 1 дүгээр баг, Аймгийн Боловсролын
газрын байранд

Утас: 70272944, Факс: 70272944

Цахим шуудан: info@to.moc.gov.mn

Цахим хуудас: www.to.moc.gov.mn

2025.12.22 № 169

танай 2025.12.01 -ны № 06/71 -т

АЙМГИЙН ЗДТГ-ЫН НИЙГМИЙН
БОДЛОГЫН ХЭЛТЭСТ

Алтанбулаг сумын 1-р багийн иргэн Лувсандамдингийн Цэрэндэжид нь уламжлалт соёлын биет бус өвийг өвлөн тээж Монголын нүүдэлчдийн соёлыг гадаад, дотоодод сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх үйл хэрэгт 36 жил хүч хөдөлмөр, оюун ухаанаа зориулж, үнэтэй хувь нэмэр оруулсан тул “Соёлын биет бус өвийн шилдэг өвлөн уламжлагч”-аар шагнуулахаар тодорхойлолтыг уламжлав.

Хавсралт: 18 хуудастай.



Төв аймгийн Соёл, урлаг, аялал
жуулчлал, залуучуудын газар

Удирдлага

Дарга

Батсуурь Тунгалаг

2025-12-22 17:51:58

**СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ СУРТАЛЧЛАН АЛДАРШУУЛАХ, ТҮГЭЭН
ДЭЛГЭРҮҮЛЭХЭД ОНЦГОЙ ХУВЬ НЭМЭР ОРУУЛСАН “ӨВЛӨН
УЛАМЖЛАГЧ”-ИЙН ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ ИРГЭНИЙ
ТАНИЛЦУУЛГА**


- | | |
|----------------------|--|
| 1. Ургийн овог | Их тэрмийн шавь |
| 2. Эцэг, эхийн нэр | Лувсандамдин |
| 3. Өөрийн нэр | Цэрэндэжид |
| 4. Регистрийн дугаар | НА50112764 |
| 5. Нас, хүйс | 75, эм |
| 6. Яс үндэс | Халх |
| 7. Үндсэн захиргаа | Төв аймаг, Алтанбулаг сум 1-р баг
Сумт 1 гудамж, 3 тоот |



**Улс, орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан
уралдаан, тэмцээнд гаргасан амжилт**

№	Шагналын нэр	Шагнагдсан он
1	Алтанбулаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 1992 оны “Шилдэг үйлдвэрлэгч” өргөмжлөл	1992
2	Төв аймгийн “Нэг сум – Нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдаанд оролцож, аймгийн бренд бүтээгдэхүүнээр шалгарч өргөмжлөл, “Хүрэл” медаль	2006
3	Төв аймгийн сумдын дунд зохион байгуулагдсан “Өрхийн үйлдвэрлэл” үзэсгэлэнд оролцож, “Хүрэл” медаль	2011
4	Улаанбаатар хот, Мишээл экспод Монголын худалдаа үйлдвэрийн танхимаас зохион байгуулсан “Намрын налгар өдрүүд” үзэсгэлэн худалдаанд гараг бүс, асар майхан, гэрийн цагаан бүрээс хийж оролцож, 3-р байр эзэлж батламж	2014
5	Төв аймгийн “Хөдөлмөрч манлай ахмад” тэмдэг	2020

ТАНИЛЦУУЛГЫГ БАТАЛГААЖУУЛСАН:
ТӨВ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАН, ЗАЛУУЧУУЛДЫН ГАЗРЫН
ДАРГА *[Signature]* БАТУНГАЛАГ



СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ШИЛДЭГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИЙН
ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЖ БУЙ ЛУВСАНДАМДИНГИЙН
ЦЭРЭНДЭЖИДИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2025.12.19

Төв аймаг.

Лувсандамдин овогтой Цэрэндэжид нь (НА50112764 регистрийн дугаартай) 1950 оны 11дүгээр сарын 27-ний өдөр Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт “Ботгоны гол” гэдэг газар айлын ууган хүүхэд болон төрсөн. Найман дүүтэй өнөр өтгөн өрхийн гишүүн. Тусгай дунд боловсролтой. Мал аж ахуйн ажилд тусалж, бага насаа эцэг эхийн гар дээр өнгөрөөсөн. 1968 онд 8-р ангиа төгсөөд Худалдааны техникумын бараа судлалын ангид элсэн суралцсан. 1970 онд Төв аймгийн худалдаа бэлтгэлийн удирдах газар, 1971 оноос Төв аймгийн Алтанбулаг сумын Худалдаа бэлтгэлийн ангид нэг системдээ 30 гаруй жил ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан.

Ажиллах хугацаандаа 1986 онд “Системийн Аварга” барааны мэргэжилтэн, 1987 онд Социалист уралдаанд түрүүлж “100 давсан хувьтан” гэрчилгээ, 1992 онд “Сумын тэргүүний сэхээтэн”-ээр шалгарч “Худалдааны тэргүүний ажилтан” цол тэмдэг, 2022 онд “Алтангадас” одон, Ардын хувьсгалын 50, 60, 70, 80, 90, 100 жилийн ойн болон Худалдааны 85, 90, 100 жилийн ойн медалиар тус тус шагнагдаж байсан.

Л.Цэрэндэжид нь уламжлалт аргаар гяраг бүс нэхэх, сүлжих урлагийн хадам аав Лувсаннамсрайгаас. Анх гяраг бүсийг 1937 онд хадам эцэг Лувсаннамсрай нь Туулын гүний хүрээнд Унзад лам байхдаа цагаан тэмээний ноосыг ээрүүлээр ээрч нэхээд, байгалийн шороон будаг цост оруулан лам нарынхаа бүсийг жигдлэн нэхэж байжээ. Их хэлмэгдүүлэлтийн үед Лувсаннамсрай нь өөрийн ганц хүү болох Л. Самдан, Л.Цэрэндэжид нарт зааж өвлүүлсэн. Л. Цэрэндэжид нь өөрийн үр хүүхэд, ач зээ нартаа буюу дөрөв дэх үедээ заан өвлүүлж байна.

Төв аймаг, Улаанбаатар хотод зохиогддог үзэсгэлэн худалдаануудад оролцож, Алтанбулаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн “Шилдэг үйлдвэрлэгч” өргөмжлөл 1 удаа, аймгийн “Нэг сум–Нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдаанд оролцож, аймгийн брэнд бүтээгдэхүүнээр шалгарч өргөмжлөл, “Хүрэл” медалиар 1 удаа, “Өрхийн үйлдвэрлэл” үзэсгэлэнд оролцож, “Хүрэл” медалиар 1 удаа, Улаанбаатар хот, Мишээл экспод Монголын худалдаа үйлдвэрийн танхимаас зохион байгуулсан “Намрын налгар өдрүүд” үзэсгэлэн худалдаанд гяраг бүс, асар майхан, гэрийн цагаан бүрээс хийж оролцож, 3-р байр 1 удаа, аймгийн “Тэргүүний үйлдвэрлэгч ахмад” медалиар тус тус шагнагдаж байсан.

Л.Цэрэндэжид нь гяраг бүсийг уламжлалт аргаар нэхэх, сүлжих чиглэлээр 4 үе дамжин ажиллахын зэрэгцээ залуу хойч үедээ үйл ажиллагаагаа өвлүүлэн үр хүүхэд, ач зээ, ЕБС-ийн сурагчдад, насанд хүрэгчдэд гэрээр болон танхимаар хичээллүүлж сургаж байна.

Үүнээс гадна Монголын Соёлын биет бус өвийн уламжлалт гар урлал төрлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр:

Орчин үеийн дээл нь дээр бүслэхэд тохиромжтой өнгө материалын сонголттойгоор нэхэн, үйлдвэрлэж малчид, урлаг, соёлынхон, бөхчүүд, лам нар, аялагч жуулчдад хийж өгөх зэргээр эдийн засгийн эргэлтэд нийцсэн бүс болтол үргэлжлүүлэн хөгжүүлж байна. 1992-2005 онд гяраг бүс нэхэх уламжлалт аргыг өөрийн үр хүүхэд, ач зээ болон их дээд сургуулийн оюутан, Алтанбулаг, Баян-Өнжүүл, Өндөрширээт, Дэлгэрхаан, Бүрэн, Эрдэнэсант зэрэг тойргийн сумдын нийт 100 гаруй хүнд уламжлалт гар аргаар гяраг бүс нэхэхийг зааж сурган, өвлөн уламжлуулсан байна.

Л.Цэрэндэжид нь уламжлалт гар аргаар 35 жилийн хугацаанд нийт 1235 гараг бүс, 10 асар, 31 майхан, 40 гэрийн цагаан даавуу /дотуур, гадуур/ зэрэг өөрийн хийсэн бүтээгдэхүүнийг захиалгаар төрийн байгууллага болон иргэнд монголын гар урлалын бүтээлүүдийг ханган нийлүүлэлт хийсэн байна.

Сурталчилсан байдал:


Гараг бүсийг модон рам дээр ороож гар аргаар нэхэж байгаа арга ажиллагааны талаар Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз 2003, 2007, 2009 оны “Өрхийн үйлдвэрлэл хөдөө орон нутагт” олон нийтийн танин мэдэхүйн нэвтрүүлэгт 3 удаа, Өлзий телевизийн 2016, 2020 оны “Төв аймагт -Өрхийн үйлдвэрлэл” нэвтрүүлэгт 2 удаа тус тус оролцсон.

2025 онд “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль оролцсон бөгөөд тэр үед МҮОНРТ-ийн “Гарвал” танин мэдэхүйн студийн нэвтрүүлэгт орж, гараг бүсний нэхэх, сүлжих аргыг үр хүүхэд, ач зээ нартаа заан сургаж байгаагаар өв уламжлалаа сурталчлан таниулах, өвлөн уламжлуулсан.

2018, 2019 онд “Madi in Mongolia, Төв аймгийн брэнд бүтээгдэхүүн” сэтгүүлийн “Шилдэг бүтээгдэхүүн гараг бүс” гарчигтайгаар хэвлэгдсэн.

Л.Цэрэндэжид нь үндэсний уламжлалт биет бус соёлын өвийн өвлөн эзэмшиж, дотоод болон гадаадад сурталчлан алдаршуулах үйл хэрэгт олон жил хүч хөдөлмөр, авьяас билгээ дайчлан, хойч үедээ үлгэр дуурайлал үзүүлж, онцгой хувь нэмэр оруулсан тул “Соёлын биет бус өвийн шилдэг өвлөн уламжлагч”-д олгох шагналд нэрийг нь дэвшүүлэн тодорхойлов.

ТӨВ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН
ДАРГА *Б.Тунгалаг* Б.ТУНГАЛАГ





**ТӨВ АЙМГИЙН
АЛТАНБУЛАГ СУМЫН
ЗАСАГ ДАРГА**

Сумт 1 дүгээр баг, Алтанбулаг сум, Төв аймаг, 41131
Цахим шуудан: towaltanbulag@gmail.com

2025.12.18

№

01/348

танай _____-ны № _____-т

Соёлын биет бус өвийн шилдэг өвлөн
уламжлагчийн шагналд нэр дэвшүүлж буй
Лувсандамдингийн Цэрэндэжидийн
тодорхойлолт

Алтанбулаг сумын 1-р багийн иргэн Их тэрмийн шавь овогт Лувсандамдингийн Цэрэндэжид нь (НА50112764 регистрийн дугаартай) 1950 оны 11 дүгээр сарын 27 нд Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт “Ботгоны гол” гэдэг газар айлын ууган хүүхэд болон төрсөн. Найман дүүтэй өнөр өтгөн өрхийн гишүүн. Тусгай дунд боловсролтой. Мал аж ахуйн ажилд тусалж, бага насаа эцэг эхийн гар дээр өнгөрөөсөн. 1968 онд 8 дугаар ангиа төгсөөд худалдааны техникумын бараа судлалын ангид элсэн суралцсан. 1970 онд Төв аймгийн худалдаа бэлтгэлийн удирдах газар хувиарлагдан ажилласан. 1971 оноос Төв аймгийн Алтанбулаг сумын Худалдаа бэлтгэлийн ангид нэг системдээ 30 гаруй жил ажиллаж, тэтгэвэртээ гарсан. Ажиллах хугацаандаа 1986 онд “Системийн аварга” барааны мэргэжилтэн, 1987 онд Социалист уралдаанд түрүүлж “100 давсан хувьтан” гэрчилгээгээр шагнуулсан. Ардын хувьсгалын 50, 60, 70, 80, 90, 100 жилийн ойн медаль, Худалдааны 85, 90, 100 жилийн ойн медалиар шагнагдаж байсан. Байгууллагын 1988, 1990 оны “Байгууллагын аварга” барааны мэргэжилтэн, 1992 онд “Сумын тэргүүний сэхээтэн”-ээр шалгарч “Худалдааны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнагдаж байсан. 2020 онд Хөдөлмөр алдараа тэмдэглүүлсэн. 2022 онд Төрийн дээд шагнал “Алтангадас” одонгоор шагнуулж байсан. Сумын Эх үрсийн баяраар “Наран Ээж” шагнал, Аймгийн эмэгтэйчүүдийн холбооноос “Тэнгэрлэг Ээж” шагнал, 2020 онд Төв аймгийн “Тэргүүний үйлдвэрлэгч ахмад” медаль, мөнгөн шагналаар шагнагдаж байсан. 2020 онд сумын хүндэт самбарт зураг нь тавигдсан. Анх Гярга бүсийг 1937 онд ханийн минь эцэг Лувсаннамсрай Туулын гүний хүрээнд Унзад лам байхдаа цагаан тэмээний ноосыг ээрүүлээр ээрч нэхээд байгалийн шороон будаг цост оруулан лам нарынхаа бүсийг жигдлэн нэхэж байжээ.

412505 054

Их хэлмэгдэлтийн үед өөрийн ганц хүү болох Самданд амьдрах арга ухаан болгон өвлүүлсэн нь одоог хүртэл ач зээ нар нь дөрвөн үеэрээ гярга бүсийг уламжлуулан гар аргаар нэхэж байна. Орчин үеийн дээлэн дээр бүслэхэд тохиромжтой өнгө материалын сонголттойгоор нэхэн малчид хөдөлмөрчид, урлаг соёлынхон, бөхчүүд, лам нар, аялал жуулчдад гэх мэт монгол дээлэн дээр бүслэхэд тохиромжтой эрэлтэд нийцсэн бүс болтол үргэлжлүүлэн хөгжүүлж чадсан. Зөвхөн үр ач нь нэхээд зогсохгүй орон нутгийн иргэд, тойргийн сумдаас сонирхон ирсэн хүнд харамгүй зааж сургасан нь өдгөө 100 хол давсан байна. 1992 онд шилдэг үйлдвэрлэгч 2006 онд Нэг сум нэг бүтээгдэхүүн үзэсгэлэнгээс Аймгийн брэнд бүтээгдэхүүн өргөмжлөл 2008 онд Сумдын өрхийн үйлдвэрлэл үзэсгэлэнгээс хүрэл медаль, Гярга бүс брэнд бүтээгдэхүүн болсон 2016 онд Төв аймгийн телевизээр Өрхийн үйлдвэрлэл орон нутагт нэвтрүүлэгт орж байсан. 2018,2019 онуудад Made in mongolia Төв аймгийн брэнд бүтээгдэхүүнүүд сэтгүүлд шилдэг бүтээгдэхүүнээр бичигдсэн. Мөн МҮОНРТ-ийн олон нийтийн танин мэдэхүйн нэвтрүүлгээр монгол дээлийн бүсийг модон рам дээр ороож гар аргаар нэхэж байгаа арга ажиллагааны талаар нэвтрүүлэг хийлгэн гурван удаа гарч байсан ба олон нийтийн сайтаар цацагдаж байсан. 2025 онд Нүүдэлчин фестивалд оролцон МҮОНРТ-н танин мэдэхүйн студи Гарваль нэвтрүүлэгт үр ачдаа заан сургах талаар оролцон тус тус өв уламжлалаа сурталчилан таниулж өвлөн уламжлуулахаар хичээж байна. Хүүхэд залуучуудад заан сургах талаар: Алтан булаг сумын 10-н жилийн сургуулийн 8-12 дугаар ангийн сурагчдын технологийн хичээлийн хөтөлбөрт 7 хоногийн 1 цагаар оруулах талаар сургуулийн захиралд санал оруулж нэвтрүүлэх, мөн тухайн нэхээсний технологи нь дан ганц гярга бүс биш хүзүүний ороолт, ширээний бүтээлэг гэх мэт бүтээгдэхүүн баяжуулан нэхэх боломжтойг таниулах зорилготой байна.

Л.Цэрэндэжид нь үндэсний уламжлалт биет бус соёлын өвийг өвлөн эзэмшиж, дотоод болон гадаадад сурталчлан алдаршуулах үйл хэрэгт олон жил хүч хөдөлмөр, авьяас билгээ дайчлан, хойч үедээ үлгэр дуурайлал үзүүлж, онцгой хувь нэмэр оруулсан тул “Соёлын биет бус өвийн шилдэг өвлөн уламжлагч”-д олгох шагналд нэрийг нь дэвшүүлэн тодорхойлов.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТСУУРЬ

 **МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ**
CITIZEN IDENTITY CARD OF MONGOLIA

 **Овог Family name**
Их тэрмийн шэвь
Ikhi termiin shavi

Эхэв /эх/-ийн нэр Surname
Лувсандамдин
Luvsandamdin

Нэр Given name
ЦЭРЭНДЭЖИД
Tserendejid


Хүйс Sex
Эмэгтэй /Female

Төрсний өдөр, сар, өдөр Date of birth
1950/11/27

Регистрийн дугаар Registration number
NA50112764 / NA50112764


 **Олгохон байгууллага Issuing authority**
Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар
The General Authority for State Registration

 **Олгохон өдөр, сар, өдөр Date of issue**
2012/07/30


Хувирах өдөр Date of expiry
0000/00/00

Хаяг Address
Төв, Алтанбулаг
1-р баг, Сумт
1 гудамж, 3 тоот

  **МНГ**







Монголын брэнд
ГЯРГА
 сүлжмэл бүс



Төв аймгийн брэнд бүтээгдэхүүнд зүй ёсоор ордог бүтээгдэхүүн бол гярга сүлжмэл бүс. 1992 оноос хойш Төв аймагчууд тэр дундаа Алтанбулаг сумынхан гярга сүлжмэл бүсийг нэхэж борлуулах болсон байна. Алтанбулаг сумандаа гярга сүлжмэл бүсний эрхийг С.Бямбацэрэн эзэмшдэг аж. Тэрээр 25 жилийн турш 1004 ширхэг гярга сүлжмэл бүс нэхжээ. Түүнчлэн өнгөрсөн хугацаанд 35-50 хүнд бүс нэхэх арга ажиллагаагаа зааж сурган өрхийнх нь орлогыг нэмэгдүүлж амьдралын баталгаатай болгосондоо сэтгэл хангалуун сууна. С.Бямбацэрэн 4-5 нэр төрлийн бүс нэхдэг бөгөөд цаашдаа үйл ажиллагаагаа өргөтгөн бүтээгдэхүүнийхээ сав баглаа, боодол, шошготой болохоор болоод байгаагаа бидэнд дуулгасан.

Орон нутгийн зүгээс жижиг дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа хүмүүсээ хэр харж хандаж байна гэсэн асуултанд маань "Сум орон нутгийн зүгээс болон аймгаас дэмжлэг үзүүлж буцалтгүй зээл тусламжинд хамруулж байсан. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих тал дээр ихээхэн арга хэмжээ авч байгаад баярлаж явдаг" хэмээн хариулсан. Гэхдээ олон жил өөр өөрсдийн хэмжээнд жижиг өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүмүүстээ урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр дэмжиж байвал жижиг дунд үйлдвэрүүд олноор ажиллах боломжтой гэж боддог. Сум орон нутгийн зүгээс ч дэмжиж ажилладаг. Харин жижиг цех, үйлдвэр байгуулахад ажлын байр, нэхмэлийн машин 8 цагаар ажиллах эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байр барихад зориулсан зардал мөнгө хүрэлцээ муу байгааг хэлээд энэ тал дээр анхаарал хандуулаад дэмжээд өгвөл илүү их боломж байгааг онцолсон.



Тэрээр "Нэг сум нэг бүтээгдэхүүн" үзэсгэлэн худалдаанд 2004 оноос хойш тасралтгүй оролцож Төв аймгийн брэнд бүтээгдэхүүн болон шилдэг бүтээгдэхүүн, алт, мөнгө, хүрэл медаль өргөмжлөл хүртжээ.






Л. ЦЭРЭНДЭЖИДИЙН ОРОЛЦСОН ТЕЛЕВИЗИЙН НЭВТРҮҮЛЭГИЙН
ЖАГСААЛТ (DVD-Д ХУУЛСАН)


1. 2025 онд “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль оролцсон бөгөөд тэр үед МҮОНРТ-ийн “Гарваль” танин мэдэхүйн студын нэвтрүүлэгт орж, гараг бүсний нэхэх, сүлжих аргыг үр хүүхэд, ач зээ нартаа заан сургаж байгаагаар өв уламжлалаа сурталчилан таниулах, өвлөн уламжлуулсан.

Л. ЦЭРЭНДЭЖИДИЙН ХИЙСЭН ГЯРАГ БҮС









Л. ЦЭРЭНДЭЖИДИЙН ХИЙСЭН ГЯРАГ БҮС ХИЙХ АРГА ТЕХНОЛОГИ
БОЛОН ШАВЬ СУРГАЛТУУД

